



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/426

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 07/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд Эрдэнэбүрэн сумын төвд ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, тохижилт, хайс хийх ажилд зориулан 5,000,000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 5,000,000 төгрөг (таван сая)-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 5/07 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3.1-д тусгагдсан Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд 20 сая мод хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ